ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2022/113/-НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН 9 ЖИЛИЙН СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Зуунмод 2022 он


Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа Уул Аудит ХХК

Захирал: Ч.Мөнхтуяа

Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

## Агуулга

Товчилсон үгийн жагсаалт....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....13
3. Аудитын тайлан....14
3.1 Ерөнхий зүйл....14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт....14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....15
3.4 Материаллаг байдал....15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....17
3.8 Аудитын гол асуудал....17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....18
4. Аудитын илрүүлэлт....19
4.3 Зөвлөмж....19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл....20

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УБЕГ | Улсын бүртгэлийн ерөнхий газар |
| НХМ | Нэг хэвийн маягт |
| ТБОНӨТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль |

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/122

танай ____________ -ны № ______________ -т

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
9 ЖИЛИЙН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.БОЛОРТУНГАЛАГ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын 9 жилийн сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын 9 жилийн сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

19020388

D 2022/2022 он/ALBAN BICHIG

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **52,067,623.55** | **49,960,012.13** |
| **33** | **АВЛАГА** | 324,226.01 | 324,226.01 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 324,226.01 | 324,226.01 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 51,743,397.54 | 49,635,786.12 |
| **354** | **Хангамжийн материал** | 49,301,397.54 | 47,684,786.12 |
| 35420 | Аж ахуйн материал | 42,576,956.69 | 38,563,118.56 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 64,660.00 | 150,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 00.00 | 2,311,886.71 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 6,659,780.85 | 6,659,780.85 |
| 35600 | Мал амьтад | 2,442,000.00 | 1,951,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **549,637,388.51** | **512,570,035.79** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **549,637,388.51** | **512,570,035.79** |
| **392** | **Биет хөрөнгө** | **500,760,388.51** | **463,132,702.47** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 510,542,853.35 | 510,542,853.35 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (67,352,886.85) | (100,718,832.25) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 75,264,426.06 | 79,936,833.55 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (56,958,650.07) | (57,078,199.62) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 70,748,841.42 | 67,733,540.28 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (47,889,576.38) | (55,029,270.94) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 2,891,000.00 | 2,891,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (1,590,049.89) | (2,168,249.85) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 772,000.00 | 772,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (615,799.88) | (695,999.84) |
| 39217 | Ном | 14,948,230.75 | 16,947,027.79 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **48,877,000.00** | **49,437,333.32** |
| 39301 | Програм хангамж | 1,542,360.00 | 2,194,360.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,267,360.00) | (1,359,026.68) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 48,602,000.00 | 48,602,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **601,705,012.06** | **562,530,047.92** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **140,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **140,000.00** |
| **413** | **Өглөг** | **00.00** | **140,000.00** |
| **4136** | **Бусад өглөг** | **00.00** | **140,000.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 140,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **601,705,012.06** | **562,390,047.92** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 601,705,012.06 | 562,390,047.92 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 229,056,929.12 | 229,056,929.12 |
| 51101 | Өмч: - төрийн | 229,056,929.12 | 229,056,929.12 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (207,683,199.54) | (246,998,163.68) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (207,683,199.54) | (207,683,199.54) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | (39,314,964.14) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 580,331,282.48 | 580,331,282.48 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **601,705,012.06** | **562,530,047.92** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* * /төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **570,674,195.81** | **598,826,132.92** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **17,106,157.50** | **12,994,417.92** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 17,106,157.50 | 12,994,417.92 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө/ | 0.00 | 9,606,097.04 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал / | 0.00 | 3,374,320.88 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 17,106,157.50 | 14,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **114,356,538.31** | **137,337,015.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 439,211,500.00 | 448,494,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 16,333,938.31 | 33,245,515.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 13,959,000.00 | 33,245,515.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 104,091,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 104,091,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **594,570,646.05** | **637,625,610.74** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **594,570,646.05** | **637,625,610.74** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 546,279,344.31 | 583,789,042.12 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 335,850,195.00 | 357,027,932.00 |
| 210101 | Үндсэн цалин | 257,445,587.00 | 240,236,629.90 |
| 210102 | Нэмэгдэл | 44,508,700.00 | 86,741,012.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,926,000.00 | 7,166,000.00 |
| 210104 | Урамшуулал | 20,351,367.00 | 16,337,486.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,618,541.00 | 6,546,804.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 42,033,512.57 | 46,378,937.56 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,103,185.93 | 32,787,225.43 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,358,501.95 | 3,482,898.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,686,801.56 | 1,915,501.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 625,320.19 | 1,535,269.41 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,259,702.94 | 6,658,041.77 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 93,746,304.00 | 99,407,840.05 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,691,104.00 | 2,313,740.05 |
| 210302 | Түлш, халаалт | 91,025,200.00 | 97,094,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,280,200.00 | 12,577,619.01 |
| 210401 | Бичиг хэрэг | 352,800.00 | 361,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 514,000.00 | 414,660.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 650,000.00 | 525,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,643,400.00 | 1,369,800.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 9,786,659.01 |
| **2105** | **Нормативт зардал** | 19,039,095.31 | 12,328,835.06 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 276,500.00 | 500,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 18,762,595.31 | 11,828,835.06 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 998,960.00 | 1,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 998,960.00 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 126,000.00 | 223,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 126,000.00 | 223,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 49,887,377.43 | 54,844,878.44 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 635,500.00 | 1,500,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,928,900.00 | 2,989,015.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 47,322,977.43 | 50,355,363.44 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 48,291,301.74 | 53,836,568.62 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 20,402,100.00 | 38,441,348.23 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 5,543,100.00 | 9,572,148.23 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 24,246,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 13,959,000.00 | 4,623,200.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,031,738.31 | 11,711,560.44 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,031,738.31 | 11,711,560.44 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 3,277,336.00 | 3,683,659.95 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,277,336.00 | 3,683,659.95 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 515,486.32 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 515,486.32 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **00.00** | **(515,486.32)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(23,896,450.24)** | **(39,314,964.14)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 229,056,929.12 | 580,331,282.48 | (152,219,288.46) | 657,168,923.14 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **229,056,929.12** | **580,331,282.48** | **(152,219,288.46)** | 657,168,923.14 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 5 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | (31,567,460.84) | (31,567,460.84) |
| 8 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **229,056,929.12** | **580,331,282.48** | **(207,683,199.54)** | 601,705,012.06 |
| 9 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **229,056,929.12** | **580,331,282.48** | **(207,683,199.54)** | 601,705,012.06 |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 11 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **229,056,929.12** | **580,331,282.48** | **(207,683,199.54)** | 601,705,012.06 |
| 16 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | (39,314,964.14) | (39,314,964.14) |
| 17 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **229,056,929.12** | **580,331,282.48** | **(246,998,163.68)** | 562,390,047.92 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **553,568,038.31** | **585,831,715.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **553,568,038.31** | **585,831,715.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 439,211,500.00 | 448,494,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 16,333,938.31 | 33,245,515.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 13,959,000.00 | 33,245,515.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 104,091,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 104,091,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **547,718,338.31** | **581,634,315.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **547,718,338.31** | **581,634,315.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **499,427,036.57** | **526,483,914.61** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 335,716,433.88 | 355,903,726.80 |
| 210101 | Үндсэн цалин | 230,413,992.95 | 188,414,065.70 |
| 210102 | Нэмэгдэл | 62,648,388.93 | 131,840,805.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,676,689.00 | 10,652,000.00 |
| 210104 | Урамшуулал | 29,977,363.00 | 24,996,856.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 42,167,273.69 | 47,363,142.76 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,687,373.69 | 32,956,242.76 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,134,100.00 | 3,601,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,322,400.00 | 2,881,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 639,000.00 | 720,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,384,400.00 | 7,203,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 93,746,304.00 | 99,407,840.05 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,691,104.00 | 2,313,740.05 |
| 210302 | Түлш, халаалт | 91,025,200.00 | 97,094,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,194,760.00 | 2,945,315.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 330,000.00 | 425,315.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 578,660.00 | 500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 650,000.00 | 500,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,516,100.00 | 1,400,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 19,541,105.00 | 15,972,890.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 276,500.00 | 500,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 18,044,605.00 | 12,826,890.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,220,000.00 | 2,646,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 998,960.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 998,960.00 | 1,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 126,000.00 | 223,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 126,000.00 | 223,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,011,200.00 | 3,668,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 748,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,011,200.00 | 2,920,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **48,291,301.74** | **55,150,400.39** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 20,402,100.00 | 39,755,180.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 5,543,100.00 | 10,885,980.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 24,246,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 13,959,000.00 | 4,623,200.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 3,277,336.00 | 3,683,659.95 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,277,336.00 | 3,683,659.95 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 22,580,127.43 | 11,711,560.44 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 22,580,127.43 | 11,711,560.44 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **5,849,700.00** | **4,197,400.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **5,849,700.00** | **4,197,400.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **5,849,700.00** | **4,197,400.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 5,849,700.00 | 4,197,400.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 5,849,700.00 | 4,197,400.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Дансны Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **552,586,200.00** | **537,190,979.61** | **15,395,220.39** | 97.2 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **552,586,200.00** | **537,190,979.61** | **15,395,220.39** | 97.2 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **540,710,000.00** | **526,304,999.61** | **14,405,000.39** | 97.3 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **360,174,000.00** | **355,903,726.80** | **4,270,273.20** | 98.8 |
| 210101 | Үндсэн цалин | 242,179,100.00 | 188,414,065.70 | 53,765,034.30 | 77.8 |
| 210102 | Нэмэгдэл | 82,707,300.00 | 131,840,805.10 | -49,133,505.10 | 159.4 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 11,484,000.00 | 10,652,000.00 | 832,000.00 | 92.8 |
| 210104 | Урамшуулал | 23,803,600.00 | 24,996,856.00 | -1,193,256.00 | 105.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **48,623,400.00** | **47,363,142.76** | 1,260,257.24 | 97.4 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,216,500.00 | 32,956,242.76 | 1,260,257.24 | 96.3 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,601,700.00 | 3,601,700.00 | 0.00 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,881,400.00 | 2,881,300.00 | 100.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 720,300.00 | 720,400.00 | -100.00 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,203,500.00 | 7,203,500.00 | 0.00 | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **103,091,500.00** | **99,407,840.05** | 3,683,659.95 | 96.4 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,797,400.00 | 2,313,740.05 | 3,483,659.95 | 39.9 |
| 210302 | Түлш, халаалт | 97,094,100.00 | 97,094,100.00 | 0.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 0 | 200,000.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **3,795,000.00** | **3,749,400.00** | 45,600.00 | 98.8 |
| 210401 | Бичиг хэрэг | 350,000.00 | 349,000.00 | 1,000.00 | 99.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 500,000.00 | 500,000.00 | 0.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 500,000.00 | 500,000.00 | 0.00 | 100.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 285,000.00 | 280,400.00 | 4,600.00 | 98.4 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 160,000.00 | 120,000.00 | 40,000.00 | 75.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,000,000.00 | 2,000,000.00 | 0.00 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **21,118,100.00** | **15,972,890.00** | 5,145,210.00 | 75.6 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 500,000.00 | 500,000.00 | 0.00 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 17,918,100.00 | 12,826,890.00 | 5,091,210.00 | 71.6 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,700,000.00 | 2,646,000.00 | 54,000.00 | 98.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,000,000.00** | **1,000,000.00** | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **223,000.00** | **223,000.00** | 0.00 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 223,000.00 | 223,000.00 | 0.00 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,685,000.00** | **2,685,000.00** | 0.00 | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,400,000.00 | 1,400,000.00 | 0.00 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,285,000.00 | 1,285,000.00 | 0.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **11,876,200.00** | **10,885,980.00** | 990,220.00 | 91.7 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **11,876,200.00** | **10,885,980.00** | 990,220.00 | 91.7 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 10,955,700.00 | 10,885,980.00 | 69,720.00 | 99.4 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 920,500.00 | 0 | 920,500.00 | - |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **552,586,200.00** | **537,190,979.61** | **15,395,220.39** | 97.2 |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **448,494,700.00** | **436,783,139.56** | **11,711,560.44** | 97.4 |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 448,494,700.00 | 436,783,139.56 | **11,711,560.44** | 97.4 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **104,091,500.00** | **100,407,840.05** | **3,683,659.95** | 96.5 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 104,091,500.00 | 100,407,840.05 | **3,683,659.95** | 96.5 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **29** | **29** | - | - |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | **1** | - | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 18 | **18** | - | - |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10 | **10** | - | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **33,245,515.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **33,245,515.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,376,315.00** |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 76,315.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 76,315.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **4,300,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,300,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28,869,200.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 28,869,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 24,246,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 4,623,200.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **33,245,515.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **33,245,515.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 33,245,515.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **-** |

## 3. АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын 9 жилийн сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн ашиглах жилийг сунгах, авлага, өглөгийн тооцоо нийлэх, хөрөнгийн дансны ангилалтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-аас 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Уваа уул Аудит ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанар хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын 9 жилийн сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Уваа уул аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын 9 жилийн сургууль нь бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг. Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- "Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хууль
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай"
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол "Босго үнэ шинэчлэн батлах тухай"
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа БШУС-ын 2021 оны бодлогын баримт бичиг, журам батлах тухай А/26 дугаар тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 онд 10 дугаар сарын 10-ны өдрөөс 13-ны өдрүүдэд хяналт шалгалт хийгдэж, "ажиллагсдад цалингийн нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг алдаатай тооцсон" гэж төлбөрийн акт тогтоосон байна.

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын 9 жилийн сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 594,570.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,945.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,161.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын 9 жилийн сургууль нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

***Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:***

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 448,494.7 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 33,245.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 33,245.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

***Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:***

Үндсэн хөрөнгө дансанд 10,704.7.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 448.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,998.8 мянган төгрөгийн номын фонд, бусад хөрөнгө 652.0 нийт 13,803.5 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 4,197.4 мянган төгрөг, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 9,606.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 3,388.3 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 31,760.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 37,256.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

***Авлага, өглөгийн талаар*:**

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 324.2 мянган төгрөгийн авлага, 140.0 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

***Санхүүгийн байдлын тайлангийн талаар:***

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 49,635.7 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 513,074.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Авлага** | 324.2 | 324.2 | - |
| **Бараа материал** | 51,743.3 | 49,635.7 | (2,107.6) |
| **Үндсэн хөрөнгө** | 549,637.3 | 513,074.0 | (36,563.3) |
| **Нийт хөрөнгө** | **601,705.0** | **563,034.0** | **(38,671.0)** |
| **Өр төлбөр** | - | 140.0 | 140.0 |
| **Хуримтлагдсан үр дүн** | 601,705.0 | 562,894.0 | (38,811.0) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **601,705.0** | **563,024.0** | **(38,671.0)** |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгө данс тайлант оны элэгдлийн зардлаас голлон шалтгаалж 36,563.3 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 563,024.0 мянган төгрөг болж 38,671.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 560,500.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 150,000.0 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 710,500.0 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 157,913.8 мянган төгрөгөөр бууруулан 552,586.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 104,091.5 мянга, улсын төсвөөс 448,494.7 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 448,494.7 мянга, орон нутгийн төсвөөс 104,091.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 537,190.8 мянган төгрөгийг зарцуулж, 15,395.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 537,190.8 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь цалин хөлсний зардлыг 4,270.3 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 3,683.7 мянга, хоол хүнсний зардлыг 5,091.2 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал/үдийн цай/-ыг 3,220.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас голлон шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсөв захирагчаас Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд нийт 33,245.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 33,245.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сургуулийн үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 102.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 97.2 хувийн биелэлттэй, буюу төсвийг хэмнэлтэй зарцуулж байгууллагын хүрэх үр дүнд хүрч ажилласан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Төсвийг бүлэг дотор зардлын хэтрэлт үүсгэж нэмэгдэл цалин хөлсийг 59.4 хувиар буюу 49,133.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 673,949.9 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллага төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 8,378,7 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 250.6 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хэрэгжүүлсэн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

**4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 87,363.7 мянган төгрөгийн 4 алдаа зөрчилд 4 зөвлөмж өглөө.

**4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:*

Эзэн холбогдогчгүй 324.2 мянган төгрөгийн авлага, байгууллагад өгөх 140.0 мянган төгрөгийн өглөгийг тус тус тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Харилцагч байгууллага, иргэдтэй тооцоо нийлж авлага, өр төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх

***2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:*

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 79,101.5 мянган төгрөгийн хөрөнгө байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох“ тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

ТӨБЗГ-н тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоох, зөрчлийг давтан гаргахгүй байх

***3. Бараа материалын данстай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:*

Бараа материалын дансанд 7,938.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д ”үнэн зөв байх”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 4.15-д “Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх буюу хангамжийн зүйлс, худалдах зориулалтаар хадгалагдаж байгаа (улсын нөөцийн бараа зэрэг) бэлэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, үйлдвэрлэлийн процесст байгаа хагас боловсруулсан бүтээгдэхүүн зэрэг болно” гэж заасантай тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

УСНББОУС-17 шалгуурт нийцсэн хөрөнгийг бүртгэх, холбогдох зөвшөөрлийг авч шийдвэрлүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

***4. Шилэн данстай холбоотой асуудал***

Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 673,949.9 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

*Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны хуулийн дагуу хугацаанд нь шилэн дансанд байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Төв аймгийн Баяндэлгэр сумын Ерөнхий боловсролын 9 жилийн сургууль | 4 | 87,363.7 | | | | | | | 4 | 87,363.7 |
| | ДҮН | 4 | 87,363.7 | | | | | | | 4 | 87,363.7 |